



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 4/845

Мандалговь

Дундговь аймгийн боловсролд  
хамрагдалтыг дэмжих зөвлөлийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2021 оны A/220, A/812, A/475-ыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах, боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг шинэчлэн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: - Аймгийн Засаг даргын орлогч

Зөвлөлийн гишүүд: - Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол, гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтэн  
- Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын  
- Нийгмийн бодлогын мэргэжилтэн  
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын нарийн бичгийн дарга  
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хүүхэд хамгааллын гишүүн  
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын сэтгэл зүйч гишүүн  
- Насан туршийн боловсролын төвийн захирал  
- Тэгш хамруулах боловсролыг дэмжих төслийн бүсийн зохицуулагч  
- Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч  
- Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Хүмүүнлэг сургуулийн захирал  
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга: - Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургалт, сурх бичиг хариуцсан мэргэжилтэн

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын тусlamж, үйлчилгээг чанартай зохион байгуулахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 06 сарын 15-ны өдрийн А/258 дугаар ~~захирамжийг хүчингүй~~ болгосугай.

